

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний алба”-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/21/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор: С.Батцэцэг Утас:70543179 Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.....	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага	19
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2021.02.24 № 13

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн “Шүүхийн шинжилгээний алба”-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн “Шүүхийн шинжилгээний алба”-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020039

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/ төгрөгөөр /
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,070,730.96	6,709,139
2	АВЛАГА	61,591.96	
3	Ажиллагчидтай холбогдсон авлага	61,591.96	
4	БАРАА МАТЕРИАЛ	7,009,139	6,709,139
5	Хангамжийн материал	7,009,139	6,709,139
6	Аж ахуйн материал	4,312,829	4,312,829
7	Түлш, шатах тослох материал	300,000	
8	Бусад хангамжийн материал	2,396,310	2,396,310
9	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	351,354,335.34	340,949,292.1
10	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	351,354,335.34	340,949,292.1
11	Биет хөрөнгө	260,559,335.34	250,154,292.1
12	Барилга, байгууламж, орон сууц	246,539,963.9	246,539,963.9
13	Хуримтлагдсан элэгдэл	-11,708,055.84	-17,562,083.76
14	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000	25,000,000
15	Хуримтлагдсан элэгдэл	-20,416,666.67	-22,083,333.35
16	Машин тоног төхөөрөмж(компьютер)	58,984,629.24	61,844,629.24
17	Хуримтлагдсан элэгдэл	-46,594,595.35	-50,481,613.1
18	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,853,032.29	11,853,032.29
19	Хуримтлагдсан элэгдэл	-3,098,972.23	-4,956,303.12
20	Биет бус хөрөнгө	90,795,000	90,795,000
21	Бусад биет бус хөрөнгө	90,795,000	90,795,000
22	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	358,425,066.3	347,658,431.1
23	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	358,425,066.3	347,658,431.1
24	Засгийн газрын хувь оролцоо	358,425,066.3	347,658,431.1
25	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	252,293,654.92	252,293,654.92
26	Хуримтлагдсан үр дүн	27,477,990.06	16,711,354.86
27	Өмнөх үеийн үр дүн	15,834,191.51	27,477,990.06
28	Тайлант үеийн үр дүн	11,643,798.55	-10,766,635.2
29	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,653,421.32	78,653,421.32
30	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	358,425,066.3	347,658,431.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	164,645,965.99	149,723,400
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,916,365.99	4,941,000
3	Нийтлэг татварын бус орлого	28,916,365.99	4,941,000
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,150,100.26	2,081,000
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,733,500	2,081,000
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,416,600.26	
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,766,265.73	2,860,000
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,729,600	144,782,400
9	Улсын төвлөрсөн төсвөөс	135,729,600	140,514,900
10	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	135,729,600	140,514,900
11	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,267,500
12	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,707,000
13	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,560,500
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	151,968,167.44	160,490,035.2
15	УРСГАЛ ЗАРДАЛ	151,968,167.44	160,490,035.2
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150,192,792.68	157,042,788.49
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,963,944	114,677,852.96
18	Үндсэн цалин	61,186,857	72,298,423
19	Нэмэгдэл	43,003,697.47	35,271,755
20	Унаа хоолны хөнгөлөлт	7,773,389.53	7,107,674.96
21	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,209,324	3,527,186.59
22	Тэтгэврийн даатгал	4,209,324	907,587.93
23	Тэтгэмжийн даатгал		710,032.03
24	ҮОМШӨ-ний даатгал		60,748.04
25	Эрүүл мэндийн даатгал		1,848,818.59
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,845,325.28	7,556,671.5
27	Гэрэл, цахилгаан	463,725.28	494,671.5
28	Түлш, халаалт	5,829,600	6,510,000
29	Цэвэр, бохир ус	552,000	552,000
30	Хангамж, бараа материалын зардал	10,235,514	11,985,000
31	Бичиг хэрэг	1,612,500	1,700,000
32	Тээвэр, шатахуун	6,068,000	3,436,500
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	834,274	900,000

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

34	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000	81,000
35	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,624,740	5,867,500
36	Нормативт зардал	4,470,881	3,899,999.7
37	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,470,881	3,899,999.7
38	Эд хогшил, урсгал засварын зардал	413,000	449,684
39	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	413,000	449,684
40	Томилолт, зочны зардал	1,904,000	496,000
41	Дотоод албан томилолт	1,904,000	496,000
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,112,595	1,185,350.5
43	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	981,300	788,850.5
44	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000	
45	Даатгалын үйлчилгээ	200,000	200,000
46	Тээврийн хэрэгслийн татвар	50,000	73,500
47	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,500	33,000
48	Газрын төлбөр	90,795	90,000
49	Бараа үйлчилгээний бусад зардал	8,038,209.4	13,265,043.24
50	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,038,209.4	13,265,043.24
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,775,374.76	3,447,246.71
52	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,775,374.76	3,447,246.71
53	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,775,374.76	3,447,246.71
54	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	12,677,798.55	-10,766,635.2
55	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,034,000	
56	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,034,000	
57	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,643,798.55	-10,766,635.2

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	15,834,191.51	346,781,267.75
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	15,834,191.51	346,781,267.75
3	Тайлант үеийн үр дүн			11,643,798.55	11,643,798.55
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	27,477,990.06	358,425,066.3
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	27,477,990.06	358,425,066.3
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	27,477,990.06	358,425,066.3
7	Тайлант үеийн үр дүн			-10,766,635.2	-10,766,635.2
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	252,293,654.92	78,653,421.32	16,711,354.86	347,658,431.1

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/ төгрөгөөр /	
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	139,463,100	146,863,400		
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,733,500	2,081,000		
3	Нийтлэг татварын бус орлого	3,733,500	2,081,000		
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,733,500	2,081,000		
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,733,500	2,081,000		
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,729,600	144,782,400		
7	Улсын төвлөрсөн төсвөөс	135,729,600	140,514,900		
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	135,729,600	140,514,900		
9	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,267,500		
10	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,707,000		
11	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,560,500		
12	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	139,463,100	146,863,400		
13	УРСГАЛ ЗАРДАЛ	139,463,100	146,863,400		
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,687,725.24	143,416,153.29		
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	112,025,535.96	114,616,261		
16	Үндсэн цалин	61,186,857	72,236,831.04		
17	Нэмэгдэл	43,065,289.43	35,271,755		
18	Унаа хоолны хөнгөлөлт	7,773,389.53	7,107,674.96		
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,209,324	3,527,186.59		
20	Тэтгэврийн даатгал	4,209,324	907,587.93		
21	Тэтгэмжийн даатгал		710,032.03		
22	ҮОМШӨ-ний даатгал		60,748.04		
23	Эрүүл мэндийн даатгал		1,848,818.59		
24	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,845,325.28	7,556,671.5		
25	Гэрэл, цахилгаан	463,725.28	494,671.5		
26	Түлш, халаалт	5,829,600	6,510,000		
27	Цэвэр, бохир ус	552,000	552,000		
28	Хангамж, бараа материалын зардал	7,213,464	11,685,000		
29	Бичиг хэрэг	1,204,000	1,700,000		
30	Тээвэр, шатахуун	4,068,000	3,136,500		
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	834,274	900,000		
32	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000	81,000		
33	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,011,190	5,867,500		
34	Нормативт зардал	2,964,481	3,899,999.7		

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

35	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,964,481	3,899,999.7
36	Эд хогшил, урсгал засварын зардал	413,000	449,684
37	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	413,000	449,684
38	Томилолт, зочны зардал	1,904,000	496,000
39	Дотоод албан томилолт	1,904,000	496,000
40	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,112,595	1,185,350.5
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	981,300	788,850.5
42	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000	
43	Даатгалын үйлчилгээ	200,000	200,000
44	Тээврийн хэрэгслийн татвар	50,000	73,500
45	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,500	33,000
46	Газрын төлбөр	90,795	90,000
47	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,775,374.76	3,447,246.71
48	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,775,374.76	3,447,246.71
49	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,775,374.76	3,447,246.71
50	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	0.00
51	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
52	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	142,314,900	139,148,653.29	3,166,246.71
2	УРСГАЛ ЗАРДАЛ	142,314,900	139,148,653.29	3,166,246.71
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	142,314,900	139,148,653.29	3,166,246.71
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,432,200	114,616,261	815,939
5	Үндсэн цалин	62,146,300	72,236,831.04	- 10,090,531.04
6	Нэмэгдэл	43,109,900	35,271,755	7,838,145
7	Унаа хоолны хөнгөлөлт	10,176,000	7,107,674.96	3,068,325.04
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,554,700	3,527,186.59	2,027,513.41
9	Тэтгэврийн даатгал	1,200,000	907,587.93	292,412.07
10	Тэтгэмжийн даатгал	1,440,000	710,032.03	729,967.97
11	ҮОМШӨ-ний даатгал	100,000	60,748.04	39,251.96
12	Эрүүл мэндийн даатгал	2,814,700	1,848,818.59	965,881.41
13	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,862,000	7,556,671.5	305,328.50
14	Гэрэл, цахилгаан	800,000	494,671.5	305,328.5
15	Түлш, халаалт	6,510,000	6,510,000	0.00
16	Цэвэр, бохир ус	552,000	552,000	0.00
17	Хангамж, бараа материалын зардал	7,417,500	7,417,500	0.00
18	Бичиг хэрэг	1,700,000	1,700,000	0.00
19	Тээвэр, шатахуун	3,136,500	3,136,500	0.00
20	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000	900,000	0.00
21	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	81,000	81,000	0.00
22	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600,000	1,600,000	0.00
23	Нормативт зардал	3,900,000	3,899,999.7	0.30
24	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,900,000	3,899,999.7	0.30
25	Эд хогшил, урсгал засварын зардал	450,000	449,684	316.0
26	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000	449,684	316.0
27	Томилолт, зочны зардал	500,000	496,000	4000.0
28	Дотоод албан томилолт	500,000	496,000	4000.0
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,198,500	1,185,350.5	13,149.5
30	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000	788,850.5	11,149.5
31	Даатгалын үйлчилгээ	200,000	200,000	
32	Тээврийн хэрэгслийн татвар	73,500	73,500	

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

33	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000	33,000	2,000.0
34	Газрын төлбөр	90,000	90,000	
35	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	142,314,900	139,429,653.29	2,885,246.71
36	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	140,514,900	137,348,653.29	3,166,246.71
37	Улсын төсвөөс санхүүжих	140,514,900	137,348,653.29	3,166,246.71
38	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,800,000	2,081,000	-281,000.0
39	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,800,000	2,081,000	-281,000.0
40	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	17	17	17
41	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1
42	Төсвийн байгууллага	1	1	1
43	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	8	8
44	Удирдах ажилтан	1	1	1
45	Гүйцэтгэх ажилтан	7	7	7
46	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8	8	8
47	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	8	8	8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,467,500	-4,467,500
3	УРСГАЛ ЗАРДАЛ		4,467,500	-4,467,500
4	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,467,500	-4,467,500
5	Хангамж, бараа материалын зардал		4,467,500	-4,467,500
6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		4,467,500	-4,467,500
7	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,467,500	-4,467,500
8	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,467,500	-4,467,500
9	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,467,500	-4,467,500

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба”-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн тогтвортой байдалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба”-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13е/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба” нь байгууллагын ажил үйлчилгээний чанарын түвшинг нэмэгдүүлж, цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, бүх шатны удирдлагын манлайллыг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулж, албан хаагчдын мэдлэг ур чадварыг ахиулах, албаны шуурхай бэлэн байдлыг хангаж, сахилга ёс зүйг төлөвшүүлэх юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба” 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “нийт зардал” сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний 152,629.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,289.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1,717.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба”-ны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,766.6 мянган төгрөгөөр буюу 39.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	61.6	0.0	-61.6
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	7,009.1	6,709.1	-300.0
Үндсэн хөрөнгө	351,354.3	340,949.3	-10,405.0
Нийт хөрөнгө	358,425.0	347,658.4	-10,766.6
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	252,293.6	252,293.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	27,478.0	16,711.4	-10,766.6

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,653.4	78,653.4	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	358,425.0	347,658.4	-10,766.6

Авлагын дансны эхний үлдэгдэл болох 61.6 мянган төгрөгийг цалингаас суутгаж барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,709.1 мянган төгрөг болж 300.0 мянган төгрөгөөр буурсан нь шатахууны материалын эхний үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 340,949.3 мянган төгрөг болж 10,405.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө нь тайлант хугацаанд нийт 2,860.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн №А/20 дугаар тогтоолоор 3 үйлдэлт лазер принтерийг хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 16,711.4 мянган төгрөг болж 10,766.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн зардал өссөнөөс шалтгаалжээ.

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба”-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 14,922.6 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс төсөвт байгууллагын өөрийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилт, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 8,521.8 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, тогтмол зардал, хангамж, бараа материалыг зардал, бараа ажил үйлчилгээ, бусад зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлттэй холбоотой залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 190,322.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 190,322.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 48,007.6 мянган төгрөгөөр бууруулж 142,314.9 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс бууруулж баталсан нь цалин хөлс, тогтмол зардал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг өмнөх оноос нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70707 /Шүүхийн шинжилгээ/ хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 142,314.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 140,514.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,800.0 мянган төгрөгийг, улсын төсвөөс 140,514.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 140,514.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,081.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 139,429.6 мянган төгрөгийг зарцуулж, 2,885.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 139,429.6 мянга буюу 97.8 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 815.9 мянга, НДШ зардлаас 2,027.5 мянга, тогтмол зардлаас 305.3 мянга, дотоод томилолтын зардлаас 4.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 13,1 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 71707 хөтөлбөрийн 1 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 2,885.2 мянган төгрөгийн бодит хэмнэлт гарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Шүүхийн шинжилгээний хүрээлэнгээс 2,707.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,560.5 мянга, нийт 4,267.5 мянган төгрөгийн орлого төвлөрснийг бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл, аж ахуйн материалын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн шинжилгээний алба” нь 2021 онд нийт 149,362.9 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан ба 4 мэдээлэл хоцроосон бөгөөд материаллаг зөрчилгүй гэж үзэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу холбогдох заалтыг зөрчөөд ажилласан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,936.0 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 1,168.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,767.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	1,767.1	3	1,767.1	-	-	-

Албан шаардлага	2	1,168.9	2	1,168.9			
Нийт дүн	5	2,936.0	5	2,936.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,929.4 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 13,046.3 мянган төгрөгийн 4 алдааг завсрын аудитаар, 3 алдааг аудитын явцад залруулж, 1,883.1 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай нийт 1,650.0 мянган төгрөгийн залруулгыг завсрын аудитаар, 11,396.3 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгийн дүнг 325.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан
2. 2 дугаар улирлын тээвэр шатахуун, бусад хангамжийн материалын тайлангууд гаргаагүй, жолоочийн тооцооны хуудасны иж бүрдэл дутуу, 1л шатахууны үнэ тариф тодорхойгүй.
3. Барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад биет бус хөрөнгийн нярвын тайланг гаргаагүй
4. 325.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн ба тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
5. Нэмэлт санхүүжилтийн данснаас худалдан авсан 2,707.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлж авснаар бүртгэсэн
6. 11 нэр төрлийн 7,489.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг оруулаагүй
7. Нөхөж ашиглах жил оруулснаас шалтгаалан 1,199.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцогдсон

4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

4.3 АЛБАН ШААРДЛАГА

Татварын цахим бүртгэлийн системд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтыг тулган баталгаажуулаагүйгээс 1,883.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.4, ”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалтыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгүүдийг актлах болон дахин үнэлж ашиглаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.9, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэхь заалтыг зөрчсөн ба “иж бүрэн байх, оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаанд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний алба	9	14,929.4	7	13,046.3			1	1,883.1	1	0